



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН  
АУДИТЫН ГАЗАР**

**Гүйцэтгэлийн аудитын тайлан**

**ЗЭЭЛИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА ХӨДӨӨ  
АЖ АХУЙН ЗАРИМ ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ  
ХАНГАЛТГҮЙ БАЙНА**

2023 оны 08  
дугаар сар

**АУДИТЫН СЭДЭВ: ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН  
ЗЭЭЛ, ТУСЛАМЖИЙН ХӨРӨНГИЙН АШИГЛАЛТ, ҮР  
ӨГӨӨЖ**

2023 он

**АГУУЛГА**

<b>ЗЭЭЛИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА ХӨДӨӨ АЖ АХУЙН ЗАРИМ ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА</b> .....	1
<b>АГУУЛГА</b> .....	2
<b>Товчилсон үгийн тайлбар</b> .....	3
<b>Хүснэгтийн товъёг</b> .....	4
<b>Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл</b> .....	5
<b>А.ЗАСГИЙН ГАЗРЫН ШУГАМААР АВСАН ЗАРИМ ЗЭЭЛИЙГ ҮР ДҮНТЭЙ АШИГЛАЖ ЧАДААГҮЙ БАЙНА</b> .....	7
<b>A2. Хөдөө аж ахуйн салбарт зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа зарим төслүүдийн хэрэгжилт хангалтгүй байна</b> .....	7
<b>A2.1. Зарим гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүд гэрээгээр хүлээсэн үүргээ хугацаандаа биелүүлээгүй байна</b> .....	7
<b>A2.2. Бүрэн хэрэгжсэн төсөл, арга хэмжээнүүд үр өгөөж өгч эхэлсэн байна</b> .....	16
<b>В.ЗЭЭЛ, ТУСЛАМЖИЙН АШИГЛАЛТАД ТАВИХ ХЯНАЛТ ҮР НӨЛӨӨТЭЙ БАЙНА</b> .....	17
<b>В.1. Зээл, тусламжийн хөрөнгийн хэрэгжилтэд тавих хяналт үр дүнтэй байна</b> .....	17
<b>В1.1. Зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төслүүдийн мэдээллийг Шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна</b> .....	17
<b>В.2. Зээл, тусламжийн хөрөнгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн байна</b> .....	18
<b>В.2.1. Зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж ажилласан байна</b> .....	18
<b>В.2.2. Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн Нэмэлт санхүүжилт” төслийн хүрээнд хэрэгжсэн инженерийн хийцтэй хоёр худгийг орлого авч данс бүртгэлд тусгаагүй байна</b> .....	19
<b>ДҮГНЭЛТ:</b> .....	20
<b>ЗӨВЛӨМЖ:</b> .....	20
<b>ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ</b> .....	21

### Товчилсон үгийн тайлбар

УИХ	Улсын Их Хурал
АДБОУС	Аудитын дэд байгууллагын олон улсын стандарт
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
МЭХНХУС	Мал эмнэлгийн хүний нөөцийн хөгжлийн удирдлагын систем
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
СЯ	Сангийн яам
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам

### Хүснэгтийн товьёг

Хүснэгт 1	“Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуй” төслийн хүрээнд Баяннуур, Сагсай сумдад хэрэгжиж байгаа төслийн биелэлт	11
Хүснэгт 2	“Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн Нэмэлт санхүүжилт” төслөөр хэрэгжсэн Баян-Өлгий аймгийн Алтай, Булган, Буянт, Ногооннуур, Сагсай сумуудад бэлчээрт инженерийн хийцтэй 5 худаг шинээр барьж байгуулах төслийн биелэлт	12
Хүснэгт 3	“Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл”-өөс Баян-Өлгий аймагт олгосон санхүүжилт	14

## Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл

### Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Монгол Улсын Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны “ Аудитын сэдэв батлах тухай” 2022 оны 9 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”, “Аудитын жилийн төлөвлөгөө батлах” тухай А/04 дүгээр тушаалыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэв.

### Аудитын зорилт

“Хөдөө аж ахуйн салбарын зээл тусламжийн хөрөнгийн ашиглалт, үр өгөөж” сэдвээр гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт зөвлөмж гарган, УИХ болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэв.

Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитын гүйцэтгэв. Үүнд:

- Засгийн газрын шугамаар авсан зээлийг үр дүнтэй ашиглаж байгаа эсэх,
- Хандивлагч орон, олон улсын байгууллагаас авсан тусламжийн хөрөнгийн ашиглалт үр өгөөжтэй байгаа эсэх,
- Зээл, тусламжийн хөрөнгийн ашиглалтад тавих хяналтын тогтолцоо үр нөлөөтэй эсэх

### Аудитын хамарсан хүрээ

Аудитад Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, Сангийн яам, Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр төсөл хөтөлбөр хэрэгжүүлж буй аж ахуйн нэгжүүд болон хэрэгжүүлэгч холбогдох байгууллагын 2016-2022 оны үйл ажиллагааг хамруулав. Шүүхийн шийдвэртэй, хууль хяналтын байгууллагад шалгагдаж буй асуудлыг аудитад хамруулаагүй болно.

### Аудитын хязгаарлалт

Байхгүй

### Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС-100, 300, 3000-3200, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-3:2020, 6817-5:2020, 6817-7:2020, Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам болон гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал, холбогдох стандартад заасан арга зүйг ашиглан салбарын бодлого, тогтолцоо, үйл ажиллагаатай холбоотой баримт материалыг үндэслэн тулган баталгаажуулалтыг хийж, тухайн асуудал хариуцсан албан тушаалтнаас асуулга, лавлагаа, тодруулга авах зэрэг горимыг хэрэгжүүлж, аудитын асуудлын шинжилгээ болон арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, түүнд үндэслэн аудитын дүн, дүгнэлт боловсруулан зөвлөмж бэлтгэв.

**Аудитын  
бүрэлдэхүүн,  
хугацаа**

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган хянан удирдаж, аудитын менежер Х.Женисбек чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор У.Ербол, М.Айнур, аудитор Ж.Назгүл, К.Еркегүл нар хамтран гүйцэтгэв.

Аудитын талбарын ажлыг 2023 оны 06 дугаар сарын 19-ны өдрөөс 2023 оны 08 дугаар сарын 10-ны хооронд гүйцэтгэж, тайланг холбогдох үе шатны хяналтаар хянуулан аймгийн Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын тушаалаар баталгаажуулж, ҮАГ-ын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газар холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлнэ.

**Хүндрэл бэрхшээл**

Талбарын ажлыг гүйцэтгэх үе шатанд аудитад шаардлагатай баримт материал бүрэн бус, холбогдох зарим албан тушаалтнууд амралтай байсан тул баримт, материал цуглуулахад хүндрэлтэй байсан.

## **А.ЗАСГИЙН ГАЗРЫН ШУГАМААР АВСАН ЗАРИМ ЗЭЭЛИЙГ ҮР ДҮНТЭЙ АШИГЛАЖ ЧАДААГҮЙ БАЙНА**

**А2. Хөдөө аж ахуйн салбарт зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа зарим төслүүдийн хэрэгжилт хангалтгүй байна**

**А2.1. Зарим гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүд гэрээгээр хүлээсэн үүргээ хугацаандаа биелүүлээгүй байна**

### ***“Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуй” төслийн хэрэгжилтийн талаар***

“Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуй” төсөл нь Азийн хөгжлийн банк болон Монгол Улсын Засгийн газрын хооронд байгуулсан олон улсын гэрээний дагуу хэрэгжиж буй төсөл байна.

Төслийн зорилго нь уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон газар тариалангийн үйлдвэрлэлийг дэмжих замаар маркетингийн үр ашгийг дээшлүүлж, өрхийн жижиг хүнсний ногоо эрхлэгчдийн орлого, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн байна.

Сагсай, Баяннуур сумд хэрэгжиж буй усжуулалтын системийг хэрэгжүүлснээр төслийн үр дүнд тариалангийн талбайг нэмэгдүүлж, ногоочдын бүлэг үүсгэн жижиг болон дунд үйлдвэрлэлийг хөгжүүлж, хүнсний ногоо үйлдвэрлэх, ойн зурвасыг нэмэгдүүлнэ гэж тооцсон байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам (ХХААХҮЯ)-ны захиалгаар Азийн хөгжлийн банк, Ядуурлыг бууруулах Японы сангийн санхүүжилттэй “Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуй” L3895/L3896/G9205-MON төслийн хүрээнд Баян-Өлгий аймгийн Сагсай сумын нутагт дэвсгэрт хэрэгжих CW-7-2 багцын дугаартай услалтын системийг шинэчлэн сайжруулах барилгын ажлын “Улаан дэл” дэд төслийн гүйцэтгэгчээр “Эс энд Эй трейд” ХХК, CW-7-1 багцын дугаартай услалтын системийг шинэчлэн сайжруулах барилгын ажлын Баяннуур сумын “Цул улаан” дэд төслийн гүйцэтгэгчээр “Нью констракшн” ХХК шалгарсан байна.

ХХААХҮЯам нь гэрээний үнийн дүн нь 4,151.8 сая төгрөгийн CW-7-2 дугаартай гэрээг Сагсай сумын усжуулалтын системийг шинэчлэн сайжруулах “Улаан дэл” дэд төслийн гүйцэтгэгч “Эс энд Эй трейд” ХХК-тай 2021 оны 9 сарын 20-ны өдөр байгуулсан бөгөөд ажлыг гүйцэтгэж дуусах хугацаа нь 2023 оны 9 сарын 01-ний өдөр байна.

Мөн гэрээний үнийн дүн нь 4,608.1 сая төгрөгийн CW-7-1 дугаартай гэрээг Баяннуур сумын усжуулалтын системийг шинэчлэн сайжруулах “Цул улаан” төслийн гүйцэтгэгч “Нью констракшн” ХХК-тай 2021 оны 12 сарын 01-ны өдөр гэрээ байгуулсан ба ажлыг гүйцэтгэж дуусах хугацаа нь 2023 оны 12 сарын 01-ний өдөр байна.

Сагсай сумын “Улаан дэл”, Баяннуур сумын “Цул улаан” услалтын системийн ажлын зураг төслийг “Хидро инженеринг” ХХК хийж гүйцэтгэж, Барилгын хөгжлийн төвөөс 2021 оны 04 дүгээр сарын 20-нд магадлал хийгдсэн байна.

“Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуй” төслийн хүрээнд хэрэгжиж буй Баяннуур сумын усжуулалтын системийн “Цул улаан”, Сагсай сумын усжуулалтын системийн “Улаан дэл” дэд төслүүдийн ажлын явцыг холбогдох баримт бичгүүд болон газар дээр нь танилцаж үзэхэд дараах байдалтай байна.

1.Сагсай сумын усжуулалтын системийг шинэчлэн сайжруулах “Улаан дэл” дэд төсөл нь Сагсай сумаас баруун тийш 10 км орчим газар “Бах харагай” хэмээх газрын хуучин системийн баруун болон зүүн хойд талбайг хамарсан байна. Нийт 400 га талбайг хамарч усжуулалтын системийг шинэчилж байна.

Төслийн зорилт нь:

- Услалтын системийн ба ус зайлуулах (шаардлагатай бол) дэд бүтцийг шинэчлэн сайжруулж, уур амьсгалын нөлөөнөөс хамгаалах,
- Услалтын системийн менежмент, дэд бүтэц, газар ашиглалт, усалгааны ус хангамжийг сайжруулах, ган гачиг, хуурайшлаас сэргийлэн усан сан барьж байгуулах болон ус түгээх суваг, усалгааг зүй зохистой, хүртээмжтэй түгээх,
- Шинэчлэн сайжруулсан усалгаатай талбайг тойруулан хамгаалалтын ойн зурвас байгуулах

Сагсай сумын “Улаан дэл” дэд төслийн ажлыг 2022 оны 04 дүгээр сарын 20-нд эхэлсэн бөгөөд 2022 оны жилийн эцсийн байдлаар нийт барилга угсралтын ажлын гүйцэтгэл 74 хувьтай буюу 3,087.5 сая төгрөгийн ажлыг хийж гүйцэтгэсэнээр ХХААХҮЯ-д тайлагнаж, 914.0 сая төгрөгийн урьдчилгаа санхүүжилт авч, үлдэгдэл 2,173.5 сая төгрөгийг нэхэмжилсэн байна.

“Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуй” төслийн 2022 оны хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээ үнэлгээний тайлангаар ажлын хөтөлбөр, графикийн хүрээнд 2022 онд барилгын ажлын 75 хувийг гүйцэтгэхээр төлөвлөсөн боловч ажлын гүйцэтгэл 2022 оны 12 дугаар сарын байдлаар 68 хувьтай буюу 2022 оны төлөвлөгөөний биелэлт 91 хувьтай байна гэж дүгнэсэн байна.

Барилгын бараа материалын үнийн өсөлт, хомсдолоос шалтгаалан гүйцэтгэгч компаниудын 2022 онд хэрэгжүүлэх ажлууд нь төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй байна.

Сагсай сумын “Улаан дэл” дэд төслийн хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.

- Хамгаалалтын төмөр торон хашаа нийт урт 11.4 км,
- Толгойн барилга,
- Гол суваг төмөр бетон хавтан доторлогоотой, цутгамал шалтай нийт урт 2,530 метр,
- Сагсай гол дээрх усны төвшин өргөх далангийн ажлын 2/3 нь хийгдсэн,
- Ус дамжуулах хоолойн ажил талбайн гол хэсгээр үргэлжилнэ. Нийт урт 4,930 метр,
- Гол сувгийн төмөр бетон хавтангийн гаргалгааны гагнуур, заадасны шавардлага, хөвөөний бетоны ажил,
- Хүн мал гарах гүүрний дам нуруу, хавтангийн цутгалт.

Сагсай сумын “Улаан дэл” дэд төслийн усжуулалтын системийн голоос эх авах хэсгийн ажил



Эх сурвалж: Төслийн хэрэгжилтийн явцын баримтжуулалт

Сагсай сумын “Улаан дэл” дэд төслийн шуудуу татсан байдал



Эх сурвалж: Төслийн хэрэгжилтийн явцын баримтжуулалт

Сагсай сумын “Улаан дэл” дэд төслийн ус дамжуулах хоолойн угсралт, торон хашаа татсан байдал



Эх сурвалж: Төслийн хэрэгжилтийн явцын баримтжуулалт

2.Баяннуур сумын усжуулалтын системийг шинэчлэн сайжруулах “Цул улаан” дэд төсөл нь Баяннуур сумаас урьд зүгт 161 га талбай газрыг хамарсан байна.

“Цул улаан” дэд төслийн ажлыг 2022 оны 05 дугаар сарын 15-нд эхэлж, 2022 оны жилийн эцсийн байдлаар нийт ажлын 31 хувь буюу 1428.5 сая төгрөгийг ажлыг хийж гүйцэтгэснээр тайлагнаж, 460.0 сая төгрөгийн урьдчилгаа санхүүжилт авсан байна.

Хяналт шинжилгээ үнэлгээний 2022 оны тайлангаар ажлын хөтөлбөр, графикийн хүрээнд тайлант онд барилгын ажлын 50 хувийг гүйцэтгэхээр төлөвлөсөн боловч 31 хувийг гүйцэтгэж, төлөвлөсөн түвшинд хүрээгүй буюу 68 хувийн гүйцэтгэлтэй байна гэж дүгнэсэн байна.

Барилгын бараа материалын үнийн өсөлт, хомсдолоос шалтгаалан гол сувгийн налуу бетон бэлдцийн ажил саатсан байна. Бараа материалын татан авалтаас шалтгаалан сар гаруй хугацаанд ажил завсарласнаар 2022 онд хэрэгжүүлэх ажлууд нь төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй байна.

Баяннуур сумын усжуулалтын системийн “Цул улаан” дэд төслийн хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

- Хуучин толгойн барилгыг буулгах,
- Толгойн барилгын газар шорооны ажлын ухах, тэгшилэх, улны болон ханын арматурчлал, ул, ханын цутгалт,
- Чиглүүлэх далан,
- Хаалт 2 ширхэг,
- Хамгаалалтын торон хашаа,
- Төмөр бетон хавтанг арматурчлах,
- Хуучин сувгийн хавтан хуулах ажил,
- Гол сувгийн тэгшилгээ,
- Гол сувгийн ул цутгалт,
- Гол сувгийн төмөр бетон хавтан тавих,
- Элсэн бэлтгэл үе 90м3
- Хайрга 3000м3

Баяннуур сумын “Цул улаан” дэд төслийн толгойн барилгын хэсгийн ажил, хагтан цутгалт, шуудуу хийх барилга угсралтын ажил



Эх сурвалж: Төслийн хэрэгжилтийн явцын баримтжуулалт

**Хүснэгт 1.** “Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуй” төслийн хүрээнд Баяннуур, Сагсай сумдад хэрэгжиж байгаа төслийн биелэлт

( сая төгрөг)

№	Төслийн нэр	Гэрээний дүн	Биелэлт	Хувь
1	Сагсай сумын усжуулалтын системийг шинэчлэн сайжруулах “Улаан дэл” дэд төсөл	4,151.8	2,823.2	68%
2	Баяннуур сумын усжуулалтын системийг шинэчлэн сайжруулах “Цул улаан” дэд төсөл	4,608.1	1,428.5	31%

Эх сурвалж: “Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуй төсөл”-ийн 2022 оны хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан

Дээрх байдлаас дүгнэж үзэхэд 2022 оны жилийн эцсийн байдлаар Сагсай сумын усжуулалтын системийн “Улаан дэл” дэд төслийн барилгын ажлын гүйцэтгэл тайлант оны төлөвлөсөн ажлын 91 хувьтай, Баяннуур сумын усжуулалтын системийн “Цул улаан” дэд төслийн барилгын ажлын гүйцэтгэл төлөвлөсөн ажлын 68 хувьтай буюу төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй байна.

Барилгын бараа материалын үнийн өсөлт, хомсдолоос шалтгаалан гол бараа материалын татан авалт удааширнаас 2022 онд хэрэгжүүлэх ажлууд нь төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй байдалд нөлөөлсөн байна.

#### **“Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн Нэмэлт санхүүжилт” төслийн хэрэгжилтийн талаар**

Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр “Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн Нэмэлт санхүүжилт” төслөөр хэрэгжсэн гэрээний үнэ нь 117.9 сая төгрөгийн дүнтэй Баян-Өлгий аймгийн Алтай, Булган, Буянт, Ногооннуур, Сагсай сумуудад бэлчээрт инженерийн хийцтэй 5 худаг шинээр барьж байгуулах тендерт шалгарсан “Нармаржан” ХХК-тай Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам 2020 оны 06 дугаар сарын 22-ны өдөр 200701/05-234 дугаартай гэрээ байгуулсан бөгөөд ажлыг гүйцэтгэж дуусгах хугацаа нь 2020 оны 08 дугаар сарын 31-ний өдөр байна.

ХХААХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2021 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн Т-210705/04-234 дугаар тэмдэглэлээр Нармаржан” ХХК-тай байгуулсан гэрээг дүгнэсэн бөгөөд 4 худгийн ажлыг гэрээний хугацаанд, 1 худгийг он дамжин дусгасан тул гэрээний ерөнхий нөхцөл болон тусгай нөхцөлийн холбогдох заалтын дагуу 3.3 сая төгрөгийн алданги тооцсон байна.

ХХААХҮЯ-аас гүйцэтгэгч “Нармаржан” ХХК-д 2020 оны 12 дугаар сарын 22-ны өдөр ажлын гүйцэтгэлийн 70 хувь буюу 82.5 сая төгрөгийн, 2021 оны 09 дүгээр сарын 09-нд үлдсэн 29.7 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус олгосон байна. (алданги 3.3 сая төгрөг, техникийн хяналтын зардлын 2.4 сая төгрөгийг хасаж тооцсон)

**Хүснэгт 2.** “Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн Нэмэлт санхүүжилт” төслөөр хэрэгжсэн Баян-Өлгий аймгийн Алтай, Булган, Буянт, Ногооннуур, Сагсай сумуудад бэлчээрт инженерийн хийцтэй 5 худаг шинээр барьж байгуулах төслийн биелэлт

( сая төгрөг)

№	Төслийн нэр	Гэрээний дүн	Олгосон санхүүжилт	Хувь
1	“Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн Нэмэлт санхүүжилт” төслөөр хэрэгжсэн Баян-Өлгий аймгийн Алтай, Булган, Буянт, Ногооннуур, Сагсай сумуудад бэлчээрт инженерийн хийцтэй 5 худаг шинээр барьж байгуулах	117.9	114.5	97%

Эх сурвалж: БӨ аймгийн бэлчээрт инженерийн хийцтэй 5 худаг шинээр барьж байгуулах ажил гүйцэтгэх гэрээний дүгнэсэн тэмдэглэл

Гүйцэтгэгч Нармаржан ХХК нь аймгийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 24-ны өдрийн А/1092 тоот захирамжаар томилогдсон ажлын хэсэгт дараах 4 худгийг акт үйлдэж хүлээлгэж өгсөн байна. Үүнд:

1. Алтай сумын 1 дүгээр багийн Хар нуурт барьсан худгийг 2021 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 01/2023 дугаартай актаар,
2. Буянт сумын 2 дугаар багийн Хөлцөөтэд (Хөндий сайлын ам) барьсан худгийг 2021 оны 12 дугаар сарын 25-ны өдөр 02/2023 дугаартай актаар,
3. Ногооннуур сумын 2 дугаар багийн Чихтэйд барьсан худгийг 2021 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 03/2023 дугаартай актаар,
4. Булган сумын 3 дугаар багийн Бага хуурайн салаад барьсан худгийг 2021 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 04/2023 дугаартай актаар тус тус хүлээж авсан байна.

Харин Сагсай сумын 3 дугаар багийн Хар уул хэмээх газарт барьсан инженерийн хийцтэй худгийг тус багийн малчдын зүгээс “пад пад” мотор тавих ёстой гэсэн шаардлага тавьж, гомдол гаргасан тул хүлээлгэж өгөөгүй байна.

Гүйцэтгэгч “Нармаржан” ХХК-ийн зүгээс “техникийн нөхцөлд усны төвшний гүнээс хамааран ус өргөх хүчин чадалтай генератор буюу мотор тавьж олгох ёстой гэсэн” тайлбар хэлж байгаа боловч малчин айл өрхүүдийн гомдлын дагуу “пад пад” мотор тавьж өгөхөөр тохиролцсон байна.

Аудитын дүнгээр дээрх зөрчлийг арилгаж, худгийг ашиглалтад хүлээлгэж өгөх талаар гүйцэтгэгч “Нармаржан” ХХК-д албан шаардлага хүргүүлэв.

*Алтай сумын 1 дүгээр багийн Хар нуур хэмээх газарт барьж байгуулсан гүний худаг*



Эх сурвалж: Ногооннуур сумын 2 дугаар багийн Чихтэйд барьж байгуулсан гүний худгийн фото зураг



Эх сурвалж: Буянт сумын 2 дугаар багийн Хөлцээтэд барьж байгуулсан гүний худгийн фото зураг



Эх сурвалж: Булган сумын 3 дугаар багийн Бага хуурайн салаад барьж байгуулсан гүний худгийн явцын фото зураг



Эх сурвалж: Төслийн хэрэгжилтийн явцын фото зураг

### **“Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл”-ийн хэрэгжилтийн талаар**

Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй “Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл”-өөс Баян-Өлгий аймагт 14.3 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна. Үүнд:

- Мал эмнэлгийн төвийн болон орон нутгийн байгууллагын хамтын ажиллагааг сайжруулах, малын гоц халдварт өвчний цаг үеийн мэдээллийг шуурхай солилцох, орон нутгийн мэргэжилтнүүдийг мэдээллээр хангах, тэдэнд зориулан сургалт зохион байгуулах зэрэг мэдээлэл, харилцаа холбооны бэлэн байдлын чадавхыг сайжруулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор 4.2 сая төгрөгийн үнэ бүхий хурлын танхимын тоног төхөөрөмжийн иж бүрдлийг аймгийн Мал эмнэлгийн газарт нийлүүлсэн байна.
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Сайдын 2020 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн А/385 дугаар тушаалаар батлагдсан “Төгсөлтийн дараах үргэлжилсэн сургалт явуулах болон малын эмчид итгэмжлэл олгох, түдгэлзүүлэх, цуцлах журам”-ын хүрээнд 3 багц цагийн хоёр хөтөлбөрөөр сумдын малын эмч нарт шинээр нэвтэрч байгаа үргэлжилсэн сургалтын тогтолцоог танилцуулах, шинэлэг арга барилаар үргэлжилсэн сургалтыг хийх замаар малын эмч нарыг чадавхжуулах, Мал эмнэлгийн хүний нөөцийн хөгжил удирдлагын систем /МЭХНХУС/-ийг нэвтрүүлэх, малын өвчний тандалт ба хяналт, хүнсний аюулгүй байдлыг сайжруулах, малын өвчний хяналтын арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх замаар хил дамнасан малын халдварт болон гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрсдэлд суурилсан өвчний тандалт ба хяналтын тогтолцоог сайжруулах, мал сүргийн эрүүл мэндийн эрсдэлийг удирдах орон нутгийн иргэдийн оролцоонд суурилсан санаачилгуудыг дэмжих, мал сүргийн эрүүл мэндийн эрсдэлийг тодорхойлох, мал эмнэлгийн чанартай үйлчилгээг орон нутагт оновчтой хүргэх аргачлалыг боловсруулах, хэвшүүлэх талаар сургалт зохион байгуулж 8.2 сая төгрөг зарцуулсан байна.

- Улаанхус, Цэнгэл, Толбо сумдаас тус бүр 70 малчныг малын эрүүл мэндийн суурь мэдлэг олгох сургалтад хамруулахад 2.1 сая төгрөгийн төсөв зарцуулж 280 ширхэг "Малчдад зориулсан" гарын авлагыг тараасан байна.

**Хүснэгт 3. “Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл”-өөс Баян-Өлгий аймагт олгосон санхүүжилт**  
( сая төгрөг)

№	Төслийн нэр	Олгосон санхүүжилт
1	Мал эмнэлгийн газарт олгосон хурлын танхимын тоног төхөөрөмжийн иж бүрдэл	4.1
2	Малын эмч нарт зохион байгуулсан сургалт	8.2
3	Улаанхус, Цэнгэл, Толбо сумдаас тус бүр 70 малчныг хамруулсан сургалт (гарын авлага)	2.0
	<b>Нийт</b>	<b>14.5</b>

Эх сурвалж: Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төслийн хүрээнд орон нутагт хэрэгжүүлсэн үйл ажиллагааны той

**A2.2. Бүрэн хэрэгжсэн төсөл, арга хэмжээнүүд үр өгөөж өгч эхэлсэн байна**

“Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуй” төслийн хүрээнд Баяннуур сумын усжуулалтын “Цул улаан” дэд төсөл хэрэгжсэнээр нийт 161 га талбайг ашиглахаар төлөвлөсөн бөгөөд уг систем нь 20 сувгаас бүрдсэнээс эхний 1-12 сувагт хүнсний ногоо, ногоон өвс тарих, 13-20 сувагт мод тарьж, тариаланчдын бүлгийг дэмжиж ажиллахаар төлөвлөжээ.

Сагсай сумын “Улаан дэл” дэд төсөл хэрэгжсэнээр 320 га талбайг ашиглах боломжтой гэж үзсэн бөгөөд үүний 64 га талбайд төмс, хүнсний ногоо тарих, 256 га талбайд малын тэжээл тарьж ашиглахаар төлөвлөсөн боловч орон нутгийн захиргааны байгууллагаас тодорхой шийдвэр гараагүй, эрх зүйн актаар баталгаажуулаагүй байна. Эдгээр төслүүдийн хэрэгжиж дуусах хугацаа болоогүй байна.

“Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн Нэмэлт санхүүжилт” төслийн хүрээнд Баян-Өлгий аймгийн Алтай сумын 1 дүгээр багийн (Хар нуур) 20 малчин өрх, Булган сумын 3 дугаар багийн (Бага хуурайн салаа) 6 малчин өрх, Буянт сумын 2 багийн 20 малчин өрх, Ногооннуур сумын 2 дугаар багийн 20 малчин өрх ундны цэвэр усаар тогтмол хангагдах нөхцөл бүрдсэн байна.

Сагсай сумын 3 дугаар багийн Хар уул хэмээх газарт барьсан инженерийн хийцтэй худаг ашиглалтад орсноор тус багийн 20 малчин айл өрх ундны цэвэр усаар хангагдах боломжтой болох юм байна.

“Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл”-ийн хүрээнд тус аймгийн төвийн Мал эмнэлгийн газрыг тоног төхөөрөмжтэй болгосноор төвөөс алслагдсан аймаг, орон нутгийн малын эмч мэргэжилтнийг оролцуулан цахим хурал, онлайн сургалт зохион байгуулах, мал эмнэлгийн салбар дахь мэдээлэл, харилцаа холбооны бэлэн байдал сайжирч байгаагаас гадна салбар хоорондын хамтын ажиллагаа сайжирч, халдварт өвчинтэй тэмцэх хариу арга хэмжээг үр дүнтэй, шуурхай зохион байгуулах боломжтой болжээ.

Түүнчлэн сумдын малын эмч нарт сургалт зохион байгуулснаар малын эмчийн цуглуулсан багц цаг болон итгэмжлэлийн хугацааг “Мал эмнэлгийн хүний нөөцийн хөгжил удирдлагын систем”(МЭХНХУС)-ээр хянах, малын эмч, мэргэжилтэнд зориулсан сургалт, мэдээллүүд уг системээр дамжин хүргэх нөхцөл бүрдсэн, мөн тус системд малын эмч, мэргэжилтнүүд бүртгүүлснээр хувь хүний мэдээллээ харах, хянах, баяжуулах, шаардлагатай сургалтад цахимаар бүртгүүлэх, цахимаар шалгалт өгөх, мэдээлэл солилцох боломж бүрдсэн байна.

Малчдад зохион байгуулсан сургалтаар малчид өөрийн мал сүргийг халдвараас хамгаалах мэдлэг, дадалтай болохоос гадна халдварт өвчний сэжигтэй тохиолдлыг эрт илрүүлж мал эмнэлгийн байгууллагад шуурхай мэдээлэх чадвартай, малчид мал эмнэлгийн үйлчилгээний ач холбогдлыг бүрэн ойлгож, мал эмнэлгийн нэгдсэн арга хэмжээнд малаа бүрэн хамруулдаг болсон гэж дүгнэсэн байна.

## **В.ЗЭЭЛ, ТУСЛАМЖИЙН АШИГЛАЛТАД ТАВИХ ХЯНАЛТ ҮР НӨЛӨӨТЭЙ БАЙНА**

### **В.1. Зээл, тусламжийн хөрөнгийн хэрэгжилтэд тавих хяналт үр дүнтэй байна**

#### **В1.1. Зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төслүүдийн мэдээллийг Шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор 2022, 2023 оны [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хөдөө аж ахуйн салбарын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжсэн хөнгөлөлттэй зээл, төслүүдийг шилэн дансны мэдээлэлд мэдээлсэн эсэхийг аудитын явцад шалгав.

Хөдөө аж ахуйн салбарын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжсэн хөнгөлөлттэй зээл, төслүүдийг <https://shilendans.gov.mn/organization/62944> сайтад байршуулж ажилласан байна.

#### **В1.2. Төсөл арга хэмжээний хэрэгжилтэд эрх бүхий байгууллагуудаас хяналт тавьж ажилласан байна**

“Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуй” төслийн хүрээнд хэрэгжиж буй Сагсай сумын “Улаан дэл”, Баяннуур сумын “Цул улаан” усжуулалтын системийн хэрэгжилтэд зураг төсвийн байгууллагаас, захиалагч болох Барилгын хөгжлийн төв, аймгийн ГХБХБГ-аас хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна.

Төслийн хэрэгжилтийн явцыг зураг төслийн байгууллага “Хидро инженеринг” ХХК, Барилгын хөгжлийн төвийн инженерүүд хянаж, барилгын улаан дэвтэрт гарсан алдаа, дутагдлыг тэмдэглэж ажилласан байна. Тухайлбал:

Баяннуур сумын “Цул улаан” усжуулалтын системийн хэрэгжилтэд захиалагч байгууллагаас нийт 12 төрлийн үүрэг даалгавар өгсний 9 үүрэг даалгаврыг биелүүлж, 3 ажлыг засварлах бэлтгэл ажил хийгдэж байна гэж тайлан ирүүлсэн байна. Зураг төслийн байгууллагаас 6 шаардлага, зөвлөмж хүргүүлсний 3

шаардлагыг биелүүлсэн, 2 ажил засварлагдаагүй, 1 ажил үерийн усны түвшин нэмэгдсэн тул хянах боломжгүй гэсэн тайлан ирүүлсэн байна.

Сагсай сумын “Улаан дэл” усжуулалтын системийн барилгын улаан журналд зураг төслийн байгууллагаас 5 удаагийн хяналтаар 19 төрлийн шаардлага, зөвлөмж хүргүүлсний 12 шаардлагыг биелүүлсэн байна.

Захиалагч байгууллагаас 5 удаагийн хяналтаар 22 шаардлага, зөвлөмж хүргүүлсний 15 шаардлагыг биелүүлсэн байна.

Төслийн хэрэгжилтэд төсөл хэрэгжүүлэх нэгжээс хяналтыг хэрэгжүүлж, төслийн явцын мэдээг сар бүр авч байсан бөгөөд 2022 оны жилийн эцсийн төслийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ үнэлгээ хийж, тайлагнаж ажилласан байна

“Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн Нэмэлт санхүүжилт” төслөөр хэрэгжсэн Баян-Өлгий аймгийн Алтай, Булган, Буянт, Ногооннуур, Сагсай сумуудад бэлчээрт инженерийн хийцтэй 5 худаг шинээр барьж байгуулах төслийн хэрэгжилтийн явцын хяналтыг тухайн сумдаас томилогдсон ажлын хэсэг болон холбогдох бусад албан тушаалтнууд хяналт тавьж акт үйлдэж ажилласан байна.

## **В.2. Зээл, тусламжийн хөрөнгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн байна**

### **В.2.1. Зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж ажилласан байна**

Засгийн газрын 2016 оны 176 дугаар тогтоолоор баталсан “Гадаад тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх, тайлагнах журам”-ын 23 дугаар зүйлийн 23.2-т “Хяналт шинжилгээ үнэлгээний ажлын хэсэг нь төслийн хэрэгжилтийн явцын үнэлгээг жил бүр дараа жилийн эхний улиралд багтаан хийх бөгөөд үнэлгээний тайланг гадаадын тусламжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан “Төслийн үнэлгээний тайлангийн загвар” маягтын дагуу боловсруулна. Төсөл хэрэгжүүлэх нэгж нь тайланг төслийн удирдах хороонд тухай бүр танилцуулж, холбогдох мэдээлэл, тайланг Удирдлагын мэдээллийн системд оруулна” гэж заасан байна.

“Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуй” төслийн 2022 оны хэрэгжилтэд Хяналт шинжилгээ үнэлгээний ажлын хэсэг үнэлгээ хийсэн байна

Хяналт-шинжилгээ үнэлгээний тайлангаас товч дурдвал дараах байдалтай байна.

Төслийн нэгж нь 2022 онд 4 зорилтын хүрээнд 50 арга хэмжээ төлөвлөсөн бөгөөд жилийн эцсийн тайланд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр тушаалаар баталсан Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, үнэлгээ хийхэд арга хэмжээний дунджаар 48.0 хувьтай гэж үнэлсэн байна.

Баяннуур сумын “Цул улаан”, Сагсай сумын “Улаан дэл” усжуулалтын системийн хэрэгжилтэд үнэлгээ хийж дараах зөвлөмжүүдийг өгсөн байна.

- Баяннуур сумын “Цул улаан”, Сагсай сумын “Улаан дэл” усжуулалтын услалтын системийн гүйцэтгэгч байгууллагуудад санхүүжилтийг яаралтай олгож, барилгын ажлыг хуваарийн дагуу гүйцэтгүүлэх чиглэлд анхаарч ажиллах,
- Услалтын системийн барилгын үнийн өсөлттэй уялдуулан шаардлагатай гэж тооцсон нэмэлт санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх,
- Услалтын системийн ажил гүйцэтгэх гэрээнд заасны дагуу ажлын хөтөлбөрийг 30 хоног тутамд тодотгож, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах.

Хяналт-шинжилгээ үнэлгээний тайлангаас дурдвал:

**CW-7-1.** Баян-Өлгий аймгийн Баяннуур сумын “Цул улаан” услалтын системийн 160 га талбайг хамарч, усжуулах барилгын ажлын гүйцэтгэлийг 62 хувь гэж дүгнэсэн байна. Үүнд:

Барилгын явц: Гол сувгийн болон сувгийн налууугийн 3800 ш хавтангийн бэлдэц хийж, арматурын хэв бэлтгэсэн, гол сувгийн цэвэрлэгээ, ухлага, 1км гол сувгийн ул бетоны ажил, налуу хавтанг сувагт суурилуулах ажил хийгдсэн.

Санхүүжилт: Урьдчилгаа төлбөрт Азийн хөгжлийн банкнаас 460.0 сая төгрөгийг 2022 оны 9 дүгээр сарын 21-нд шилжүүлсэн.

Биелэлт: Гүйцэтгэгч нь гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу боловсруулсан 2022-2023 оны ажлын хөтөлбөр, графикийн хүрээнд 2022 онд нийт барилгын ажлын 50 хувийг гүйцэтгэхээр төлөвлөсөн. Ажлын гүйцэтгэл 2022 оны 12 дугаар сарын байдлаар 31 хувь буюу 2022 оны төлөвлөгөөний биелэлт 62 хувьтай байна.

Тулгарсан асуудал: Барилгын бараа материалын үнийн өсөлт, хомсдол зэргээс шалтгаалан гол сувгийн налуу бетон бэлдцийн ажил саатсан.

Дүгнэлт: Барилгын бараа материалын хомсдол, татан авалтаас шалтгаалан сар гаруйн хугацаанд ажил завсарласнаас 2022 оны төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй байна.

**CW-7-2.** Баян-Өлгий аймгийн Сагсай Улаан дэл услалтын системийн 400 га талбайг хамарч, усжуулах барилгын ажлын гүйцэтгэлийг 68 хувь гэж дүгнэсэн байна. Үүнд:

Барилгын явц: Толгой барилгын ажил, хамгаалалтын торон хашааны ажилд 2800 ш шон суулгаж дууссан, ус дамжуулах хоолойн шуудууны ухлагийг хийж гүйцэтгэн, гол сувгийн хавтан цутгалт, угсралт, гол сувгийн шалны ажил, усны түвшин өргөх далангийн болон ус дамжуулах Ф400 мм хоолойн наалтыг бүрэн хийж дуусгасан байна.

Санхүүжилт: Азийн хөгжлийн банкнаас урьдчилгаа төлбөрт 377.0 сая төгрөгийг, ажлын гүйцэтгэл санхүүжилтэд 430.0 сая төгрөгийг, нийт 807.0 сая төгрөгийг гэрээт компанид олгосон.

Биелэлт: Ажлын хөтөлбөр графикийн хүрээнд 2022 онд нийт барилгын ажлын 75 хувийг гүйцэтгэхээр төлөвлөсөн. Ажлын гүйцэтгэл 2022 оны 12 сарын байдлаар 68 хувьтай буюу 2022 оны төлөвлөгөөний биелэлт 91 хувьтай байна.

**B2.2. Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн Нэмэлт санхүүжилт” төслийн хүрээнд хэрэгжсэн инженерийн хийцтэй хоёр худгийг орлого авч данс бүртгэлд тусгаагүй байна**

Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төслөөр аймгийн Мал эмнэлгийн газарт олгосон 4.0 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдөр орлогод авч данс бүртгэлд тусгасан байна.

“Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн Нэмэлт санхүүжилт” төслийн хүрээнд Баян-Өлгий аймгийн Буянт сумын 2 дугаар багийн Хөлцөөтэд (Хөндий сайлын ам) барьсан гэрээний үнэ нь 23.5 сая төгрөгийн худгийг аймгийн Засаг даргын 2021 оны А/1092 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг хүлээлгэн өгсөн боловч уг хөрөнгийг орлого авч данс бүртгэлд тусгаагүй байна.

Сагсай сумын 3 дугаар багийн Хар уул хэмээх газарт барьсан инженерийн хийцтэй худгийг малчдаас гомдол гаргасан тул хүлээлгэж өгөөгүй байна.

Аудитын дүнгээр дээрх хоёр худгийг орлого авч, данс бүртгэлд тусгаж, зөрчлийг арилгах талаар холбогдох байгууллагуудад албан шаардлага хүргүүлэв.

## **ДҮГНЭЛТ:**

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

1. Хөдөө аж ахуйн салбарт зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа зарим төслийн хэрэгжилт хангалтгүй байна
2. Зарим гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүд гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлээгүй байна
3. Ашиглалтад оруулсан төсөл, арга хэмжээнүүд үр өгөөжөө өгч эхэлсэн байна
4. Зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжсэн төсөл арга хэмжээнд эрх бүхий байгууллагаас хяналт тавьж ажилласан байна

## **ЗӨВЛӨМЖ:**

Аудитын дүнгээр зөвлөмж өгөгдөөгүй.

## ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ  
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗАР**

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг  
Утас: (976) 7042-2211

2023.08.17 № 204  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

Танай байгууллагаас Хөдөө аж ахуйн салбарын зээл тусламжийн хөрөнгийн ашиглалт, үр өгөөжид хийсэн аудитын тайлантай танилцлаа.

Тухайн аудит нь хууль, журмын дагуу хийгдсэн гэж үзэж байна. Тайлантай холбоотой ямар нэгэн санал байхгүй болно.

ДА...  


Б.НУРГУЛАН



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ДАРГА ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2023 оны 08 сарын 18 өдөр

Дугаар А/15

Өлгий

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 20 дугаар зүйлийн 20.1, 20.2, 20.4, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын хавсралтын 18 дугаар хэсгийн 18.9, 2018 оны А/207 дугаар тушаалын 5 дугаар хавсралтын 1.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Хөдөө аж ахуйн салбарын зээл, тусламжийн хөрөнгийн ашиглалт, үр өгөөж" сэдвээр хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг нэгдүгээр хавсралтаар, аудитаар өгсөн албан шаардлагыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.
2. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудит газар, Баян-Өлгий аймаг дахь Хүнс, хөдөө аж ахуйн газарт тус тус хүргүүлсүгэй.
3. Аудитаар өгсөн албан шаардлагын биелэлтийг заасан хугацаанд ирүүлэхийг холбогдох шалгагдагч байгууллагуудын дарга нарт зөвлөсүгэй.
4. Аудитын дүнгээр өгсөн албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2023 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор танилцуулахыг ахлах аудитор (У.Ербол)-д, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (Х.Женисбек)-т тус тус даалгасугай.



М.ХУАНГАН

Баян-Өлгий аймаг дахь Төрийн  
аудитын газрын дарга, тэргүүлэх  
аудиторын 2023 оны 08 дугаар  
сарын 18.-ны өдрийн 4/15 тоот  
тушаалын хоёрдугаар хавсралт

Албан шаардлагын жагсаалт

№	Байгууллагын нэр	Албан шаардлагын тоо	Албан шаардлагын мөнгөн дүн (мянган төгрөг)
1	"Нармаржан" ХХК	1	22,900.0
2	Буянт сумын ЗДТГ	1	23,592.3
	<b>Нийт дүн</b>		<b>46,492.3</b>